

**СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 4 сарын 17 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 04 сарын 27 –ний өдрийн 10:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Оффисын хоёрдугаар давхарын хурлын танхимд болов.

Хуралд оролцсон:

1. Г.Хатанболд /Хурлын дарга/
2. Л.Золбаяр /Хувьцаа эзэмшигч/
3. Н.Төгөлдөр /Тооллогын комиссын дарга/

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Н.Төгөлдөр-ийн танилцуулснаар:

Стандарт Агрикалчер Групп ХК-ийн нийт гаргасан 13,735,752 ширхэг хувьцаа байгаагаас 13,735,752 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2020 оны 4-р сарын 7-ны өдрийн байдлаар нийт 150 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 13,595,314 ширхэг хувьцаатай Стандарт капитал ХХК буюу 98.98 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсон Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дүгээр заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов. Оролцсон хувьцаа эзэмшигч:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	Стандарт капитал	13,595,314	98.98%
Нийт		13,595,314	98.98%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03-р сарын 18-ний өдрийн 2 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх тухай.

Г.Хатанболд: 2019 онд манай компани нь 3 га газар төмс тариалж, 20 га газар чацаргана мод арчилсан нийт 42,374,588.61 төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулж 51,500,000 төгрөгийн борлуулалтын орлого олж 1,470,430.25 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Л.Золбаяр: Цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулж компаний ашиг өсөн гэдэгт найдаж байна. Иймээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Шийдвэр 1:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: Охин компаниудын шинэчилсэн дүрэм батлах тухай.

Г.Хатанболд: Стандарт агрикалчер групп ХК -ийн охин компаниуд болох Органик ферм ХХК, Органик бийф ХХК, Органик порк ХХК –уудын үйл ажиллагаа нь зогсонги байдалд байгаа тул бусдад шилжүүлэх саналтай байна.

А.Золбаяр: Энэхүү саналыг дэмжиж байна.

Шийдвэр 2:

1. Охин компани Органик ферм ХХК, Органик бийф ХХК, Органик порк ХХК –уудыг бусдад ШИЛЖҮҮЛСҮГЭЙ.

Хэлэлцэх асуудал 3: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Г.Хатанболд: 2020 онд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбогдуулан ТУЗ-н гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байна.

А.Золбаяр: Компанийн үйл ажиллагаа тогтвортой хэвийн явагдаж эхлэхээр цалин урамшуулал олгоно гэдэгт итгэж байна. Иймд энэхүү саналыг дэмжиж байна.

Шийдвэр 3:

1. Компани 2020 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 4: ТУЗ-ийн гишүүдийг танилцуулах тухай.

Г.Хатанболд: 2019 оны ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгох.

Хараат бус гишүүд:

- Д.Санжид
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам

Ердийн гишүүд:

- Г.Хатанболд
- Н.Улаанхүү
- А.Золбаяр
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- С.Шагдарсүрэн

А.Золбаяр: ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгохыг дэмжиж байна.

Шийдвэр 4:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүд:

Хараат бус гишүүдэд:

- Д.Санжид
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам

Ердийн гишүүн

- Г.Хатанболд
- Н.Улаанхүү
- Л.Золбаяр
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- С.Шагдарсүрэн нарыг улируулан СОНГОСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 5: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авах тухай.

Г.Хатанболд: Стандарт агрикалчер групп ХК нь үйл ажиллагаа өргөтгөх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл саналтай байна.

Л.Золбаяр: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авахыг дэмжиж байна.

Шийдвэр 5:

1. Стандарт агрикалчер групп ХК нь жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл АВСУГАЙ.

Хурлын дарга Г.Хатанболд хуралд оролцогсдод талархал илэрхийлж 11:20 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:



Л.ГАНТУЯА

Танилцсан Хурлын дарга:

Г.ХАТАНБОЛД